

МОНГОЛ УЛСЫН ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2026 оны 04 дүгээр
сарын ...-ны өдөр

Дугаар ...

Улаанбаатар хот

Тариф батлах тухай

Эрчим хүчний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4, 9.2 дахь хэсэг, 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсэг, Эрчим хүчний зохицуулах хорооны 2024 оны 504 дүгээр тогтоолоор батлагдсан “Цахилгаан, дулааны эрчим хүчний тариф тогтоох аргачлал”-ын 3 дугаар зүйл, 4 дүгээр зүйлийн 4.5 дахь хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1 дэх хэсэг, “Алтай-Улиатайн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн 2026 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 29 дүгээр, 2026 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 65 дугаар албан бичгийг тус тус үндэслэн Эрчим хүчний зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Говь-Алтай аймгийн Алтай сумын хэрэглэгчдэд борлуулах цахилгааны тарифыг хавсралтаар баталсугай.

2. Батлагдсан тарифыг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгэж, “Захиргааны хэм хэмжээний актын эмхтгэл”-д нийтлэгдсэн өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг “Алтай-Улиастайн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК /Б.Цэдэвсүрэн/-д үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Үнэ, тарифын газар /Б.Эрдэнэбулган/-т даалгасугай.

ГАРЫН ҮСЭГ

Эрчим хүчний зохицуулах хорооны
2026 оны 04 дүгээр сарын ...-ны өдрийн
... дугаар тогтоолын хавсралт

**ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН АЛТАЙ СУМЫН ХЭРЭГЛЭГЧДЭД
БОРЛУУЛАХ ЦАХИЛГААНЫ ТАРИФ**

1. Үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллага болон айл өрхөд борлуулах цахилгааны тарифыг (НӨАТ-гүй) ангиллаас нь хамааруулан төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараах байдлаар тогтооно:

№	Ангилал	Хэмжих нэгж	Тариф
1	Уул уурхайн олборлох, боловсруулах аж үйлдвэр, зарим аж ахуйн нэгж байгууллага. Үүнд: <i>Нүүрс олборлолт, боловсруулалт</i> <i>Газрын тос, шатдаг хий олборлолт, боловсруулалт</i> <i>Төмрийн хүдэр олборлолт, боловсруулалт</i> <i>Түгээмэл тархацтай ашигт малтмал олборлолт</i> <i>Бусад ашигт малтмал олборлолт, боловсруулалт</i> <i>Банк, банкны нэгж</i> <i>Согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч</i> <i>Криптовалют олборлох, үйлдвэрлэх үйл ажиллагаа эрхлэгч</i>	төг/кВт.ц	657.00
2	Үүрэн холбооны үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч	төг/кВт.ц	657.00
3	Бусад үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллага	төг/кВт.ц	640.00
4	Айл өрх	төг/кВт.ц	343.00